



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 17 өдөр

Дугаар А/259

Номгон

Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн
ундны усны талаар авах зарим арга
хэмжээний тухай

Эрүүл мэндийн яамнаас улсын хэмжээнд 2022 онд Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн ундны цэвэр усны дээжид хийсэн лабораторийн шинжилгээний дүнгээр төвлөрсөн бус ус хангамжийн усны бохирдлын түвшин их, 10-аас дээш хувьд нь нянгийн ерөнхий тоо стандартад заасан зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс их, 2,2 хувь нь эмгэг төрөгч нянгийн бохирдолтой байгаа судалгаа гарсантай холбогдуулан Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Усны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэгийн төвлөрсөн бус ус хангамжийн эх үүсвэрт Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлал, Барилга, хот байгуулалтын сайдын хамтарсан 2015 оны А/230/127 дугаар тушаалаар баталсан “Усан сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журам”-ын хэрэгжилтийг хангуулж, шуурхай арга хэмжээг авч ажиллахыг сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

2.Сургууль, цэцэрлэгийн ундны цэвэр усны дээжид улирал тутам шинжилгээ хийж үр дүнг танилцуулж ажиллахыг Стандарт хэмжил зүйн хэлтэс (Н.Шагдарсүрэн), Бөөнцагаан -Орог нуурын сав газрын захиргаа /Б.Ням-очир/-т холбогдох арга хэмжээ авч жил бүрийн 5, 10 дугаар сарын 25-ны дотор тайлагнаж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны газар (Ж.Алтанцэцэг), Эрүүл мэндийн газар (Н.Энхжаргал) нарт тус тус үүрэг болгосугай.

3.Сургууль, цэцэрлэгийн ундны усны шинжилгээний зардлыг байгууллагынхаа жил бүрийн төсөвт тусган хэрэгжүүлж, ажиллахыг сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч нарт үүрэг болгосугай.

63171851

2.

4. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Б.Батсуурь)-д даалгасугай.

